

БСШУСЯ-наас Дэлхийн банкны санхүүжилтээр “БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ШИНЭЧЛЭЛ ” төслийн хүрээнд бага боловсролын эх хэл, математик, байгалийн ухааны боловсролын чанарыг сайжруулах зорилготой сургуулийн эрэлт, хэрэгцээнд суурилсан “СУРГУУЛИЙН ТЭТГЭЛЭГТ ” хөтөлбөрийг улсын хэмжээнд 3 үе шаттай хэрэгжүүлж, улсын хэмжээнд төрийн өмчийн 635 сургуулт хамрагдсанаас Дундговь аймгаас нэгдүгээр шатанд 8, хоёрдугаар шатанд 11, гуравдугаар шатанд 11 нийт давхардсан тоогоор сургууль түшиглэсэн 30 төсөл хэрэгжиж нийт 171 044 060 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Сургуулиуд 1, 2-р шатны төслийг хэрэгжүүлсэн туршлага, сургамжиндаа тулгуурлан 3-р шатны төслийн төлөвлөлтийг хичээлийн жилийн эхэнд нарийвчлан гаргаж, **хүүхэд бүрт** төслийн үр дүнг хүргэхэд онцгой анхааран ажиллах, мөн 1, 2-р шатны төслийн тогтвортой байдлыг ханган үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Төсөл хэрэгжсэнээр сургуулиудад дараах ололт амжилт гарч байна.

Дундговь аймагт хэрэгжиж байгаа Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр төсөл -1

№	Сургууль	төслийн нэр	Төслийн өртөг / төгрөг/
1	Хулд сумын дунд сургууль	"Алим клуб"	5994000
2	Өлзийт сумын дунд сургууль	"Гоёо"	3996000
3	Цагаандэлгэр сумын дунд сургууль	"Ном ертөнцийг харах цонх мөн"	3342500
4	Баянжаргалан сумын дунд сургууль	"Боржигоны үлгэрч багачууд"	3195680
5	Өндөршил сумын дунд сургууль	"Эх хэл эрдмийн түлхүүр"	5960000
6	Сайнцагаан сумын Говийн-Ирээдүй цогцолбор	"Сургамжит жүжиг"	3988000
7	Сайнцагаан сумын Мандал сургууль	"Бяцхан экологчид"	5960000
8	Дэлгэрцогт сумын дунд сургууль	"Гэрэлт ирээдүй"	3988000
	Бүгд		36424180

Дундговь аймагт хэрэгжиж байгаа Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр төсөл -2

№	Сургууль	төслийн нэр	Төслийн өртөг / төгрөг/
1	Сайнцагаан сумын 4 дүгээр сургууль	Эрдмийн хөтөч	6143760
2	Гурвансайхан бүрэн дунд сургууль	Хаадын домогтой хүүхдүүд- хөгжлийн танхим	6143760
3	Сайнцагаан 3 дугаар сургууль	Математик миний бидний амьдралд	6143760
4	Эрдэнэдалай сумын бүрэн дунд сургууль	Гацуурхан	6143760
5	Сайнцагаан Эрдмийн далай цогцолбор сургууль	Цэцэгт өргөө	6143760
6	Говь-Угтаал сумын дунд сургууль	Боржигон аялгуу сургалт	4095840
7	Луус сумын дунд сургууль	Эко аялал орон нутаг судлал	4084000
8	Адаацаг сумын дунд сургууль	Миний хүсэл Монгол ухаан	6143760
9	Дэлгэрхангай сумын дунд сургууль	Хүүхдийн ертөнц мэдээ	6143760
10	Дэрэн сумын дунд сургууль	Авьяас	6143760
11	Сайхан-Овоо сумын дунд сургууль	Ухаан далай номоос эхтэй	6143760
	Бүгд		63473680

Дундговь аймагт хэрэгжиж байгаа "Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр төсөл -3"

№	Сургууль	төслийн нэр	Төслийн өртөг / төгрөг/
1	Баянжаргалан сумын дунд сургууль	Бид бяцхан экологчид	3968000
2	Хулд сумын сургууль	Бид шинжлэх ухаанч	7356000
3	Сайнцагаан Мандал	Хос тархины тэнцэл	6934750
4	Сайнцагаан Говийн-Ирээдүй	Тооцоолох ухаан	6000000
5	Гурвансайхан бүрэн дунд сургууль	Бага ангийн моногл хэлний хичээл-Бодлын ертөнц	7200000
6	Сайнцагаан 3 дугаар сургууль	Бидний дуртай математик	6000000
7	Эрдэнэдалай бүрэн дунд сургууль	Теле гацуурхан	7000000
8	Сайнцагаан эрдмийн далай	Эгшиглэн дуу бичлэгийн студи	7485000
9	Луус сумын дунд сургууль	Залуу байгальч ногоон ирээдүй	4908000
10	Дэрэн сумын дунд сургууль	Эх хэл эрдмийн түлхүүр	6966450
11	Дэлгэрхангай бүрэн дунд сургууль	Бид чадна	7328000
	Бүгд		71146200

№	Сургууль	Ололт амжилт
1	Дэрэн сумын 9-н жилийн сургууль	Сургалтанд ашиглах хөгжмийн зэмсэгээр хангагдаж сурагчдын авьяасыг хөгжүүлэх орчин бүрдүүлэн ажиллаж байна.
2	Сайхан-Овоо сумын 9-н жилийн сургууль	Төслийн хүрээнд өнгөт принтер, зурагт, видео камер, дууны өсгөгч , дууны өсгөгчийн хөл, микрофонтой болж, зураг урлал, жүжиг, дуурайн зохиох дуурайн зохиох, уран уншлагын дугуйлангуудыг багш нар удирдан явуулж хүүхэд бүрийн хөгжлийг ханган ажиллаж байна.
3	Дэлгэрхангай сумын 12-н жилийн сургууль	Сургуулийн багш сурагчид мэдээ мэдээлэл бэлтгэх чадвартай болж, Сургуулийн үйл ажиллагааны талаарх “Мэдээлэл “ сэтгүүл гарган цаг алдалгүй мэдээг сурагчид эцэг эхчүүдэд хүргэн ажиллаж байна.
4	Говь-Угтаал 9-н жилийн сургууль	Сургалтанд ашиглах хөгжмийн зэмсэгээр хангагдаж сурагчдын авьяасыг хөгжүүлэх орчин бүрдүүлэн боржигон уртын болох биет бус өвөө авч үлдэх маш том боломжийг бий болгон ажиллаж байна.
5	Сайнцагаан-3 дугаар сургууль	Туршлага судлах аялалд бага багш нараа хамруулан судалсан туршлагаа өөрийн болгон хэрэгжүүлэн ажиллж байна. Үүнд: Дундговь аймгийн сургуулиуд, Говьсүмбэр аймгийн 5-р сургууль, Хэнтий аймгийн багш нарын төлөөлөл, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын сургуулийн сургалтын менежер нарт төслийн үйл ажиллагаа болон үр дүнгийн талаар танилцуулсан. Мөн Говьсүмбэр аймгийн “Сайн хичээл, тэргүүн туршлагын зөвлөгөөн”-д 23 багшийг оролцуулж СТХ-ийн 5 төслийн тайлан, үзэсгэлэн үзэж туршлага судалж, сургуульдаа хэрэгжүүлж байна.
6	Адаацаг сумын 9-н жилийн дунд сургууль	“Миний хүсэл-Монгол ухаан” клубыг ажиллуулан уламжлалт тоглоом наадгайн сан, булантай боллоо.
7	Эрдэнэдалай сумын 12 жилийн сургууль	Гацуурхан- 1 төслийн хувьд “Номын 10 хоног” болон “Болор тулга” уралдааныг үзэж, уралдаанд оролцсоноор сурагчид бие биенээсээ суралцах, өөртөө итгэлтэй зан чанар болон уран яруу унших чадвар, өрсөлдөх чадварт ахиц гарсан. Гацуурхан -2 төслийн хувьд сурагчдын хамтран ажиллах, урлах, бүтээх, өөрийгөө илэрхийлэх гэх мэт олон чадварт ахиц гарч хүүхдийн оролцоог ханган ажиллаж байгаад эцэг эхчүүд багш нар болон сурагчдын сэтгэгдэл маш өндөр байна.
8	Эрдмийн далай цогцолбор сургууль	Төслийн байгалийн ухааны хичээлийн цэцэгт ургамлын талаарх бүлэг сэдвийн дадлагыг үр дүнтэй явуулах дадлага туршлагын танхимтай болсон. Бага сургуулийн багш болон сургуулийн 1-5 р ангийн сурагчид цэцэг тарьж арчлах ургуулах онолын болон практик чадвартай болж бага ангийн сурагчид олон төрлийн цэцэг арчлан ургуулж сургуулийн орчныг ногоон орчин болоход хувь нэмрээ оруулан ажиллаж байна.
9	Луус сумын 9-н жилийн сургууль	Сургуулийн мэдээ сониньг 14 хоног тутам эрхлэн гаргаж, нийт эцэг эхчүүд, ангиудад тогтмол хүргэж хэвшсэн. Аяллын 3 маршрутын дагуу сургалтын хэрэглэгдэхүүнтэй болсон. Төслийн тогтворт байдлыг ханган, цаашид үргэлжлүүлэхэд шаардагдах “эко аялал” мэдээллийн самбар, техник хэрэглэгдэхүүнээр хангагдсан. Орон нутгаа танилцуулах чадамж бүхий “ Аяллын хөтөч ” – өөр бэлтгэгдсэн нийт хүүхдийн тоо 42 буюу 27 хувьд хүрсэн амжилттай ажиллаж байна.
10	Гурвансайхан сумын 12 жилийн сургууль	Сургалтын хөгжимтэй болсон учир морин хуурын дугуйлан хичээллэж эхэлсэн. больсон.Хичээллэх танхимгүй байсан бүжиг,найрал дуу,шатрын дугуйлан энэ төвд хичээллэж эхэлсэн. Урлаг залаа тайз, фульг өсгөгчтэй болсоноор аливаа үйл ажиллагаа зохион байгуулахад

		орчин бүрдсэн. Дугуйлангуудын тайлан тавих орчин бүрдсэн. Иргэдээс сургуулийн үйл ажиллагаанд хандах хандлага, үнэлэмж өссөн.
11	Сайнцагаан Мандал 12 жилийн сургууль	Бага ангийн байгалийн ухааны кабинеттай болж, бага ангийн сурагчдын “Байгалийн ухаан” хичээлээр танхимд эзэмших мэдлэг, чадварыг бодит орчинд нь ажиглах, судлах, мэдлэгээ хэрэглээ болгох чадварыг хөгжүүлэх бүтээлч үйл ажиллагаанд оролцуулснаар цөм хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна.
12	Сайнцагаан Говийн-ирээдүй цогцолбор сургууль	Төслийн үр дүнд бага сургууль зориулалтын тайз, жүжгийн жижиг хэрэглэл, техник хэрэгсэлэй болсон байна. Сурагчид сургууль дээрх асуудлыг олж харж бяцхан жүжиг найруулан тоглосноор сурагчдын гоо зүй, урлагийн мэдрэмж хөгжиж, өөртөө итгэх итгэл нэмэгдсэн.
13	Өндөршил сумын 9-н жилийн сургууль	Төслийн санхүүжилтээр сурагч, багш, ажилчид, эцэг эх 40 хүн оролцсон орон нутагтай танилцах 250 км-ын аялалыг хийж, гэрэл зургийн дугуйлангийн сурагчид зургийн цомог гарган, сургууль дээр зочилсон хүмүүст гарын бэлэг болгон дурсган өгч байгаагаас харахад төсөл богино хугацаанд үр дүнгээ өгч байна. “Өсвөрийн сурвалжлагчид”-ын дугуйлангийн сурагчид өөрсдөө санаачлан сайн үйлс аян зохион байгуулжээ. Сургууль дээр “Бидний дуу хоолой” радио узель ажиллуулж завсарлагаанаар дуут гимнастик болон мэдээ мэдээллийг ажиллуулж хэвшүүлжээ.
14	Өлзийт сумын 9-н жилийн сургууль	Холбооны мэдээллийн хэрэгсэл тэй болсноор сурагчид мэдээллийг заавал анги танхимаасаа гаргах шаардлагагүй болсон. Сурагчид бусдын яриаг анхааралтай сонсох, бүлгэмийн сурагчид, эмч болон сурагчид өөрсдийн мэдээллийг цаг алдалгүй танилцуулах боломжтой болсон. Мөн stem хэрэглэгдэхүүн ашиглан хүүхдийн инженерийн сэтгэлгээг хөгжүүлэн ажиллаж байна.
15	Хулд сумын 9-н жилийн сургууль	Сургууль орчны мэдээллийг сургуулийн цахим хуудас болон сургуулийн мэдээллийн самбарт байршуулж, “Алим” сэтгүүлээрээ болон танилцуулага бэлтгэн багш, сурагч, эцэг эх, бусад ард иргэдэд нээлттэй болгож байна
16	Цагаандэлгэр сумын 9-н жилийн сургууль	Сурагчид шүлэг зохиох “Болор тулга”, сэтгүүл гаргах ” “Сэтгүүлчдийн клуб”, шүлэг уран унших “Хүрэл тулга”, эцэг эх багш, сурагчид хамтран оролцсон дүрд тоглох ажлуудыг явуулснаар хүүхдүүд ном унших дуртай болсон, өгүүллэгийг дүрд орж унших, өөрөө шүлэг зохиох, ярих чадвар сайжирсан байна.
17	Баянжаргалан сумын 9-н жилийн сургууль	Сургуульдаа урьд өмнө нь байгаагүй үлгэр жишээ явуулын бага тайз, жүжгийн жижиг хэрэглэлүүдтэй болсон. Сурагчид ардын аман зохиолын өв соёл, арвин сан хөмрөгөөс суралцаж үгийн баялаг, ярианы чадвар нэмэгдэн, Сурагчдын уран зохиолын хичээлд хандах хандлага, дур сонирхол нэмэгдсэн, хичээлийн чанар стандартад ахиц гарсан байна. Боловсролын бодлого чиглэл, хүүхдийн авьяасыг хөгжүүлэх ажил ба сургуулиас зохион байгуулж буй үйл ажиллагааны талаар эцэг эх, олон нийт төр захиргааны байгууллагад сэтгэл ханамж дээшилж, хамтран ажиллах эерэг хандлага бий боллоо.



Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 2 дахь шатны үйл ажиллагааны тайлан



Баянжаргалан сум “Боржигоны үлгэрч багачууд”



Өндөршил сум “Эх хэл эрдмийн түлхүүр”